



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/124/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: **7034-2716**

Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид

Утас: **9511-2689**

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Аудитор Ш.Ганчимэг

Утас: **99377360**

Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	14-16
4. Аудитын тайлан.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17-18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	20-21
7. Алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.09.24 № 194
танай _____ ны № _____ т

САЙХАН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ж.ЗОЛБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн төвийн 2022 оны үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс төсвөөс 61,870.0 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 615,393.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас нийт зардлын гүйцэтгэл 91.6 хувьтай хэрэгжжээ.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 308,320.5 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан, 131,961.0 мянган төгрөгөөр худалдаж авсан багаж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 163,791.3 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хандив тусламжаар хүлээн авсан 21,246.9 мянган төгрөгийн хөрөнгийг, санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

D:/bichighereg/2023A4toot

006020227

Аудитын гол асуудал

Тус Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын даргын 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 8 зорилтын хүрээнд 22 арга хэмжээ баталснаас гүйцэтгэлээр 92.3 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	509,451,766.79	294,910,098.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	32,009,216.89	101,796,824.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	32,009,216.89	101,796,824.23
3121	Төгрөг	32,009,216.89	101,796,824.23
31211	Төрийн сангийн харилцах	30,580,364.89	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	1,428,852.00	-
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	101,796,824.23
33	АВЛАГА	308,570,026.24	3.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	22,057.24	3.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	308,320,500.00	-
335	Бусад авлага	227,469.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	227,469.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	168,872,523.66	193,113,271.54
351	Түүхий эд материал	134,693,117.64	133,464,609.52
35110	Тусгай зориулалттай материал	8,294,108.00	11,287,217.00
35130	Эм боох материал	126,399,009.64	122,177,392.52
354	Хангамжийн материал	34,179,406.02	59,648,662.02
35410	Бичиг хэргийн материал	770,850.00	1,462,000.00
35420	Аж ахуйн материал	19,346,981.22	23,964,281.22
35460	Хүнсний материал	14,061,574.80	34,222,380.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,131,595,075.34	1,243,658,122.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,131,595,075.34	1,243,658,122.94
392	Биет хөрөнгө	1,117,369,575.34	1,229,732,622.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,056,347,417.46	1,082,079,567.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(107,202,126.54)	(133,462,217.49)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	91,628,000.00	91,628,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(57,191,888.94)	(69,248,555.58)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	134,593,549.00	260,582,513.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,667,461.50)	(53,490,807.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,293,572.00	69,102,572.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,291,136.30)	(19,880,599.85)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	214,650.00	214,650.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,375,000.00	4,375,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,749,999.84)	(2,187,499.80)
39217	Ном	20,000.00	20,000.00
393	Биет бус хөрөнгө	14,225,500.00	13,925,500.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(382,500.00)	(682,500.00)

39303	Бусад биет бус хөрөнгө	12,958,000.00	12,958,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,641,046,842.13</u>	<u>1,538,568,221.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>136,510,619.33</u>	<u>150,256.90</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	136,510,619.33	150,256.90
413	Өглөг	136,510,619.33	150,256.90
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	467,529.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	127,982,203.80	-
4136	Бусад өглөг	8,060,886.53	150,256.90
41361	Байгууллагад төлөх өглөг	7,910,629.63	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	150,256.90	150,256.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,504,536,222.80</u>	<u>1,538,417,964.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,504,536,222.80	1,538,417,964.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	522,078,018.31	522,078,018.31
51101	Өмч: - төрийн	522,078,018.31	522,078,018.31
512	Хуримтлагдсан үр дүн	455,690,123.36	489,571,865.37
51210	Өмнөх үеийн үр дүн	455,690,123.36	455,690,123.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	33,881,742.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	526,768,081.13	526,768,081.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,641,046,842.13</u>	<u>1,538,568,221.71</u>

ЦЭСБ аудит ХХК

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,156,255,705.00	877,799,806.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	309,670,500.00	88,134,740.25
120	Нийтлэг татварын бус орлого	308,320,500.00	88,134,740.25
120002	Хүүгийн орлого	308,320,500.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	88,134,740.25
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	277,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	87,857,540.25
122	Тусламжийн орлого	1,350,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	1,350,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	846,585,205.00	789,665,066.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	418,947,900.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,947,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	341,437,205.00	25,713,006.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	24,525,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	338,474,005.00	1,187,806.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,963,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,652,680.00	61,870,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,652,680.00	-
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	61,870,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	35,547,420.00	702,082,060.00
134001	Эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлого		96,620,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,547,420.00	605,462,060.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,111,480,296.67	843,918,064.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,111,480,296.67	843,918,064.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,038,780,296.67	841,352,044.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,194,104.17	368,923,427.50
210101	Үндсэн цалин	206,521,616.25	248,966,882.28
210102	Нэмэгдэл	81,609,429.92	86,234,250.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,564,000.00	4,799,936.72
210104	Урамшуулал	19,499,058.00	28,922,358.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ши	42,671,062.70	45,141,530.40
210201	Тэтгэврийн даатгал	30,107,535.46	31,132,176.40
210202	Тэтгэмжийн даатгал	3,277,526.29	3,718,704.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,328,698.70	2,744,106.67
210204	Ажилгүйдлийн даатгал	629,251.30	685,976.65
210205	Эрүүл мэндийн даатгал	6,328,050.95	6,860,566.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,836,412.00	59,803,980.00
210301	Гэрэл, цахилгаан	4,505,180.00	2,742,748.00

210302	Түлш, халаалт	55,903,232.00	55,603,232.00
210303	Цэвэр, бохир ус	1,428,000.00	1,458,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,569,134.80	47,831,651.57
210401	Бичиг хэрэг	3,776,825.00	9,921,250.00
210402	Тээвэр, шатахуун	26,308,869.80	26,269,181.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,029,560.00	869,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,314,000.00	9,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,417,500.00	3,093,220.37
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,722,380.00	7,669,500.00
2105	Нормативт зардал	499,981,986.19	242,106,098.38
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	458,815,603.49	214,735,841.38
210502	Хоол, хүнс	41,136,382.70	27,370,257.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,581,473.00	8,250,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,274,000.00	1,947,000.00
210604	Урсгал засвар	4,307,473.00	6,303,500.00
2107	Томилолт, зочны зардал	900,000.00	602,000.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	602,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,450.00	429,539.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,450.00	339,739.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	49,000.00
210807	Газрын төлбөр	-	40,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,885,673.81	68,263,317.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,128,400.00	1,796,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	143,500.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,613,773.81	66,467,067.39
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,700,000.00	2,566,020.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,700,000.00	2,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	71,900,000.00	2,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	66,020.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	66,020.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	44,775,408.33	33,881,742.01
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,638,179.60	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,638,179.60	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,638,179.60)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,137,228.73	33,881,742.01

ЦЭСБ аудум ХХК

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	756,112,111.85	857,570,966.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	158,647.00	17,951,184.46
120	Нийтлэг татварын бус орлого	158,647.00	17,951,184.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	158,647.00	17,951,184.46
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	158,647.00	17,951,184.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	755,953,464.85	839,619,782.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	472,470,700.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	472,470,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	219,391,297.00	1,436,262.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,070,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,336,297.00	1,436,262.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,985,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,096,207.85	47,398,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,096,207.85	47,398,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,995,260.00	790,785,520.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,995,260.00	790,785,520.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	702,986,327.39	617,690,569.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	702,986,327.39	617,690,569.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	633,896,327.39	611,985,940.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,489,158.00	360,614,938.16
210101	Үндсэн цалин	239,400,167.00	250,812,020.08
210102	Нэмэгдэл	95,671,766.00	83,088,874.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,692,540.00	4,577,998.81
210104	Урамшуулал	22,724,685.00	22,136,044.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,746,142.54	47,302,409.47
210201	Тэтгэврийн даатгал	33,743,987.33	33,894,329.15
210202	Тэтгэмжийн даатгал	3,352,697.03	3,528,959.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,651,936.98	2,866,680.89
210204	Ажилгүйдлийн даатгал	628,952.34	629,312.72
210205	Эрүүл мэндийн даатгал	6,368,568.86	6,383,127.04
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,710,657.85	39,886,370.50
210301	Гэрэл, цахилгаан	2,997,810.00	2,499,199.00
210302	Түлш, халаалт	34,968,000.00	34,268,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,744,847.85	3,119,171.50
2104	Хангамж, бараа материалын зардал	34,688,567.00	33,982,363.00
210401	Бичиг хэрэг	4,955,800.00	2,112,930.00
210402	Тээвэр, шатахуун	24,127,867.00	27,217,233.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,400.00	1,367,800.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,622,500.00	3,284,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,496,000.00	-
2105	Нормативт зардал	112,072,395.00	103,197,058.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,014,620.00	84,050,092.00
210502	Хоол, хүнс	15,937,775.00	14,847,966.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,120,000.00	4,299,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,255,050.00	11,084,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	990,000.00	1,950,000.00
210604	Урсгал засвар	6,265,050.00	9,134,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,618,000.00	3,685,000.00
210702	Дотоод албан томилолт	2,618,000.00	3,685,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,449,517.00	1,259,101.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,259,900.00	862,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,750.00	114,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
210807	Газрын төлбөр	15,192.00	39,499.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	6,077.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,866,840.00	10,974,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,866,840.00	10,974,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,090,000.00	5,704,629.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,090,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,890,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,704,629.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,704,629.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>53,125,784.46</u>	<u>239,880,396.83</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	35,174,600.00	70,983,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,174,600.00	70,983,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	35,174,600.00	70,983,300.00
220001	Барилга байгууламж	-	4,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	35,174,600.00	66,483,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(35,174,600.00)</u>	<u>(70,983,300.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,951,184.46	168,897,096.83
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		17,951,184.46
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,951,184.46	168,897,096.83

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	69,826,191.59	467,431,174.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	69,826,191.59	467,431,174.69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			258,079,983.20	258,079,983.20
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	327,906,174.79	725,511,157.89
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	327,906,174.79	725,511,157.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	327,906,174.79	725,511,157.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			46,749,714.02	46,749,714.02
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	374,655,888.81	772,260,871.91

ЦЭСБ аудит ХХК

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутаг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,398,000.00	41,693,370.50	5,704,629.50	87.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,398,000.00	41,693,370.50	5,704,629.50	87.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,398,000.00	41,693,370.50	5,704,629.50	87.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,398,000.00	39,886,370.50	5,511,629.50	87.86
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,499,199.00	500,801.00	83.31
210302	Түлш, халаалт	39,598,000.00	34,268,000.00	5,330,000.00	86.54
210303	Цэвэр, бохир ус	2,800,000.00	3,119,171.50	(319,171.50)	111.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,807,000.00	193,000.00	90.35
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,807,000.00	193,000.00	90.35
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,398,000.00	47,398,000.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,398,000.00	47,398,000.00	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	47,398,000.00	47,398,000.00	0.00	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				

ЦЭСБ аудит ХХК

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Эрүүл мэндийн даатгалын сан/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	768,716,000.00	641,275,869.63	127,440,130.37	83.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	768,716,000.00	641,275,869.63	127,440,130.37	83.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	768,716,000.00	641,275,869.63	127,440,130.37	83.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,234,400.00	360,614,938.16	84,619,461.84	81.0
210101	Үндсэн цалин	271,214,800.00	250,812,020.08	20,402,779.92	92.5
210102	Нэмэгдэл	138,230,500.00	83,088,874.99	55,141,625.01	60.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,103,000.00	4,577,998.81	525,001.19	89.7
210104	Урамшуулал	30,686,100.00	22,136,044.28	8,550,055.72	72.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,664,300.00	47,302,409.47	10,361,890.53	82.0
210201	Тэтгэврийн даатгал	40,210,100.00	33,894,329.15	6,315,770.85	84.3
210202	Тэтгэмжийн даатгал	4,363,500.00	3,528,959.67	834,540.33	80.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,490,900.00	2,866,680.89	624,219.11	82.1
210204	Ажилгүйдлийн даатгал	872,700.00	629,312.72	243,387.28	72.1
210205	Эрүүл мэндийн даатгал	8,727,100.00	6,383,127.04	2,343,972.96	73.1
2104	Хангамж, бараа материалын зардал	39,755,100.00	33,982,363.00	5,772,737.00	85.5

210401	Бичиг хэрэг	3,861,600.00	2,112,930.00	1,748,670.00	54.7
210402	Тээвэр, шатахуун	27,258,800.00	27,217,233.00	41,567.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,982,400.00	1,367,800.00	614,600.00	69.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,496,000.00	3,284,400.00	2,211,600.00	59.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,156,300.00	0.00	1,156,300.00	0.0
2105	Нормативт зардал	122,947,500.00	109,897,058.00	13,050,442.00	89.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	94,187,200.00	90,750,092.00	3,437,108.00	96.4
210502	Хоол, хүнс	24,322,800.00	14,847,966.00	9,474,834.00	61.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,437,500.00	4,299,000.00	138,500.00	96.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,308,600.00	72,850,800.00	1,457,800.00	98.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	62,465,800.00	61,023,300.00	1,442,500.00	97.7
210604	Урсгал засвар	11,842,800.00	11,827,500.00	15,300.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	4,816,800.00	3,685,000.00	1,131,800.00	76.5
210702	Дотоод албан томилолт	4,816,800.00	3,685,000.00	1,131,800.00	76.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,819,600.00	1,259,101.00	8,560,499.00	12.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,993,200.00	862,000.00	6,131,200.00	12.3
210803	Даатгалын үйлчилгээ	216,400.00	170,775.00	45,625.00	78.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,400.00	114,750.00	31,650.00	78.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	69,600.00	66,000.00	3,600.00	94.8
210807	Газрын төлбөр	140,800.00	39,499.00	101,301.00	28.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,000.00	6,077.00	23,923.00	20.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,169,700.00	11,684,200.00	2,485,500.00	82.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,169,700.00	11,684,200.00	2,485,500.00	82.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	768,716,000.00	810,172,966.46	(41,456,966.46)	105.4
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	577,299,400.00	618,562,240.00	(41,262,840.00)	107.1
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	577,299,400.00	618,562,240.00	(41,262,840.00)	107.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	191,416,600.00	191,610,726.46	(194,126.46)	100.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,416,600.00	191,610,726.46	(194,126.46)	100.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	168,897,096.83	(168,897,096.83)	

ЦЭСБ аудум ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Сайхан сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлдэг төрийн байгууллага бөгөөд тайлант онд "Тусламж үйлчилгээний чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, эмч мэргэжилтнүүдийн тасралтгүй хөгжлийг дэмжих, эмнэлгийн өнөөгийн хүрсэн түвшинг хадгалж, ахиулах" гэсэн зорилтыг дэвшүүлж ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан хэрэгжсэн, Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэн, мөн Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөгүй бага гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагатай гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын Эрүүл мэндийн төв 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102,475.6 мянган төгрөгөөр буюу 6.24 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	32,009.2	101,796.8	69,787.6
Авлага	308,570.0	3.0	(308,567.0)
Бараа материал	168,872.5	193,113.3	24,240.8
Үндсэн хөрөнгө	1,131,595.1	1,243,658.1	112,063.0
Нийт хөрөнгө	1,641,046.8	1,538,571.2	102,475.6
Өр төлбөр	136,510.6	150.2	(4,559.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,504,536.2	1,538,418.0	46,749.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,641,046.8	1,538,571.2	102,475.6

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансанд 1,098,284.8 мянган төгрөгийн орлого орж, 1,028,467.2 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд бие даасан байдалд бүрэн шилжсэнтэй холбоотойгоор зарцуулаагүй 101,796.8 мянган төгрөг дансанд үлдсэн байна.

Авлага буурсан нь хувь хүмүүсээс авах 249.5 мянган төгрөгийн авлага ЭМД-ын сангаас гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл 308,320.5 мянган төгрөг орж ирсэнтэй холбоотой байна.

Бараа, материал дансны үлдэгдэл 24,240.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 249,135.9 мянга, хандив, тусламжаар 67,020.6 мянга, аймгийн Эрүүл мэндийн газраас 227.5 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 292,143.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд төсвийн хөрөнгөөр 157,693.1 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 2,220,654.7 мянга, аймгийн Эрүүл мэндийн газраас 1,077.6 мянга, хандив, тусламжаар 19,759.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан нь үндсэн хөрөнгө 112,063.0 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн.

Сайхан сумын ИТХ-аас Эрүүл мэндийн төвийн хэвийн үйл ажиллагаанд зориулан шаардагдах 131,961.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч бэлтгэх зөвшөөрөл олгож, гүйцэтгэлд хяналт шалгалт хийж ажиллажээ. Тайлант онд шилжүүлсэн болон акталсан үндсэн хөрөнгө байхгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2022 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 993,309.3 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг Орон нутгийн төсөв, туслах үйл ажиллагааны орлогоос 92,384.3 мянга, ЭМД-ын сангаас 900,925.0 мянган төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд бие даасан байдалд бүрэн шилжиж Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан тусламж, үйлчилгээний зардлыг

тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ” гэж заасны дагуу шинэ тогтолцоонд шилжин гүйцэтгэлээр ЭМД-ын сангаас санхүүжиж эхэлсэнтэй холбоотой санхүүжилтийн зарцуулах эрхийг дээд шатны төсвийн захирагч нь тухай бүр эдийн засгийн ангиллаар баталж өгчээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр ЭМД-ын сангаас 913,782.6 мянга, орон нутгийн төсвөөс 61,870.0, нэмэлт санхүүжилтийн орлого 122,333.0, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 299.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 870,804.1 мянган төгрөгийг зарцуулж, орон нутагт 66.0 мянган төгрөг төвлөрүүлж, зарцуулаагүй 101,796.8 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна. Энэ нь тухайн жилийн зарцуулаагүй үлдэгдлийг дараа онд зарцуулах эрх үүссэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	80302 1 иргэнд ногдох нормативт зардал	296,128.6	263,288.2	32,840.4	88.9
	81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	319,265.3	267,306.2	51,959.1	83.7
	83603 Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	311,909.9	294,912.6	16,997.3	94.5
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	80111 Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	61,870.0	61,870.0	-	100.0
	Дүн	989,173.8	887,377.0	101,796.8	91.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант оны эцэст нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлогыг төсвийн харилцах дансанд нэгтгэж, гүйцэтгэлийг тайлагнасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Б.Гантуяа нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн 1,666,675.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,666.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэлээр авсан санхүүжилтээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ зэрэг зардлаас 101,796.8 мянган төгрөг зарцуулаагүй нь тухайн жилийн зарцуулаагүй үлдэгдлийг дараа онд зарцуулах эрх үүссэнтэй холбоотой байна.

Харин төсвийн хөрөнгөөр хувь хүнээс 10,644.0 мянган төгрөгийн гадна, камер бусад төхөөрөмж худалдан авсан нь ТБӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.13-т “Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргаж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.5, 6.2.4, 6.3.7-д заасан 5 мэдээллийг хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргасан тул хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт /мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	893.6	1	893.6	100
Албан шаардлага	7	125,781.7	6	109,308.6	86.9
Зөвлөмж	3	96,645.7	2	96,645.7	66.7
Нийт дүн	11	223,321.0	9	206,850.9	84.5

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжөөс худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилд өгсөн 1 албан шаардлага, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтыг шалгах асуудалд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 69,800.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил¹ илэрснээс, аудитын явцад 57,701.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,455.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 10,644.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тэтгэмж, үр дүнгийн урамшууллыг шалгахад Эрүүл мэндийн төвийн даргын тушаалд үндэслэл болгосон хууль эрх зүйн заалт нь хамааралгүй, 2 ажилтанд олгосон 1,000.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийн үнэлэмж, үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Эмийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад эмийн захиалгын түүвэрт үндэслэл баримтгүйгээр зарим нэр төрлийн эм, тариаг нэмж оруулан зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

1. Эрүүл мэндийн төв нь хувь хүнээс төсвийн хөрөнгөөр 10,644.0 мянган төгрөгийн камер, бусад тоног төхөөрөмж худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-т “Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “**Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно**” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргаж, “Шилэн дансны цахим хуудас”-т 5 мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дахь “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалтыг зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Байгууллагын дотоод хяналт шалгалттай холбоотой асуудал

Илрүүлэлт

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Байгууллагын дотоод хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлээгүй, үр нөлөө хангалтгүй байгаа нь холбогдох заалт болон байгууллагын дотоод журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3-т заасан эрх үүргийг хэрэгжүүлж, хийсэн ажлын тайлан бэлтгэж, үр дүнг мэдээлж, шалгалтын үр нөлөөг сайжруулж ажиллах.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			Тоо	Дүн
							Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант оны элэгдлийг дутуу байгуулсан	1	31,969.3	1	31,969.3			1	31,969.3					
Төсвийн хөрөнгөөр баригдсан хашаа орлогод бүртгээгүй	1	25,732.1	1	25,732.1			1	25,732.1					
Дүн	2	57,701.4	2	57,701.4			2	57,701.4	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт	Тоо	Дүн	
Үр дүнгийн нэг үзүүлэлтээр тусламж, урамшуулал давхар олгосон	1	1,000.0	1	1,000.0									
Эмийн захиалгын түүвэрт үндэслэх баримтгүйгээр зарим эм, тариаг нэмж оруулсан	1	455.0	1	455.0									
Дүн	2	1,455.0	2	1,455.0									

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст 5 мэдээллийг хугацаа хоцроосон	1	0.0	-	-	1	0.0		
Дүн	1	0.0			1	0.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой	1	10,644.0			1	10,644.0		
Дүн	1	10,644.0			1	10,644.0		
Нийт дүн	2	10,644.0	-	-	2	10,644.0	-	-

